

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Мэргэжлийн боловсролын салбарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлагнал хариуцсан мэргэжилтэн, Дашмятав Долгормаа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. САНХҮҮ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
1	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэл үр дүнгийн санхүүжилтийн системийг улам төгөлдөржүүлж, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Байгууллагын тоо, санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	31 МБСБ-196.8 тэрбум төгрөг хуваарилан 100% хэвийн үйл ажиллагаа явуулсан.	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад үр дүнд суурилсан санхүүжилтийн систем бүрэн хэрэгжсэн байна	Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтыг дэмжих сангийн 2025 оны төсөв 213,998,612.1 мянган төгрөгөөр батлагдсан. Эдийн засгийн ангиллаар авч үзвэл төрийн өмчийн 31 МБСБ-д гүйцэтгэлд суурилсан санхүүжилт 131,708,677.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэвэр, урамшууллын зардалд 31 МБСБ-ын 435 ажилтан, албан хаагчдад 6,660,830.8 мянган төгрөг, 70 МБСБ-ын 20645 суралцагчдад олгох тэтгэлэгт 49,937,729.5 мянган төгрөг, төрийн бус	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					өмчийн 31 МБСБ-д 15,431,374.8 мянган төгрөг, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх сургалтын зардалд 585,000.0 мянган төгрөг, олон улсын тэмцээн уралдааны зардалд 675,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлийн үнэлгээний санхүүжилт 9,000,000.0 мянган төгрөгөөр тус тус батлагдсан байна. Засгийн газрын 466 дугаар тогтоолын дагуу хувьсах зардлыг тооцоолон төлөвлөгөөний программд 11 хөтөлбөрийн 26 эдийн засгийн ангиллаар 2025 оны 1-12 сарын төлөвлөгөөг хуваарилан шивж оруулан Сангийн яам, Боловсролын яам, МБСБайгууллагуудад хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		
2	Боловсролын салбарын төсвийн гүйцэтгэл, үр дүнг Төсвийн ерөнхийлөн захирагч, Боловсролы сайдын өмнө хариуцан ажиллах	Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	ЗГ-ын 466 дугаар тогтоолын дагуу санхүүжилтийг хүүхдийн тоотой уялдуулан тооцож сар бүрийн 10-ны дотор, төрийн бус өмчийн МБСБ-ын санхүүжилтийг	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийг цаг тухайд нь олгож, байгууллагуудын санхүү, төсвийн	Сангийн яамнаас батлагдсан төсвийн хуваарийн дагуу 90,559,491.8 мянган төгрөгийн санхүүжих төлөвлөгөөтэйгөөс 90,282,943.5 мянган төгрөгийн санхүүжилтийг мэргэжлийн боловсрол,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р	100%

			квот, гүйцэтгэлийн дагуу тооцож дараа бүрийн 15-ны дотор тогтмол санхүүжүүлсэн.	хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан байна.	сургалтыг дэмжих сангийн дансанд хүлээн авч хөтөлбөр, зориулалт, арга хэмжээний дагуу 2025 оны эхний 05 сарын байдлаар төрийн өмчийн 31, төрийн бус өмчийн 31 байгууллагуудад 90,282,943.5 мянган төгрөгийн гүйцэтгэлээрх санхүүжилтийг маягтын дагуу төрийн сангийн программд боловсруулан олгосон байна. Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу үндсэн үйл ажиллагаанаас бусад хөтөлбөр, зориулалт, арга хэмжээний зардлын санхүүжилтийг СЭБ-3 маягтаар Сангийн яамд холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн хүргүүлж эхний 05 сарын байдлаар тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд 7 МБСБ-ын 8 ажилтанд 197,834.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд 266,136.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч гүйлгээг холбогдох байгууллагуудад шилжүүлсэн. Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил	сар, 11-р сар, 12-р сар	
--	--	--	---	---	---	-------------------------	--

					дээшүүлэх сургалтын зардалд 34,857.9 мянган төгрөгийн зардлыг тушаалын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн гүйлгээ хийж гүйцэтгэсэн байна. Төрийн бус өмчийн 31 МБСБ-ын ирцийн мэдээг дараа сарын 5-ны дотор авч ЗГ-ын 466 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлээр тооцоолон 30 байгууллагад эхний 5 сарын байдлаар 6,014,136.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. ЗГ-ын 421 дүгээр тогтоолын дагуу шаардлага хангасан МБСБ-ын 45 сургуулийн 6559 өвлийн төгсөгчдөд 31,351,200.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дансны мэдээлэл, овог нэр, регистрийн дугаараар тулган холбогдох баримтыг бүрдүүлэн төрийн сангийн программаар нэг бүрчлэн шивж гүйлгээг хийсэн. Төрийн сангийн удирдлагын нэгдсэн системд төлбөр тооцооны гүйлгээг холбогдох баримтыг үндэслэн хялбаршуулсан горимоор дэмжих сангийн данснаас 6759 гүйлгээний		
--	--	--	--	--	---	--	--

					37,612,26.6 мянган төгрөгийн зарлагыг гүйлгээг хийсэн байна. Хавсралт: 1 файл		
1.2. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ							
3	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Улсын төсвөөс олгох санхүүжилтийг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, тайлагнах, хяналт тавих ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах	Байгууллагын тоо, санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Төрийн бус өмчийн 31 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт олгосон	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад Улсын төсвөөс олгож буй санхүүжилтийг гүйцэтгэл, үр дүнгээр олгосон байна.	Төсвийн тухай хуулийн цаглабарын дагуу сар бүрийн 2-нд мэргэжлийн боловсролын салбарын байгууллагуудаас төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр, авлагын мэдээг Динамик программаар авч тулган алдааг тухай бүр залруулан ажиллаж байна. 2025 оны эхний 05 сарын байдлаар төрийн өмчийн 31 МБСБ-ын төсвийн гүйцэтгэлийн мэдээг тулган өр, авлагын мэдээгээр эхний 5 сарын байдлаар 450,669.6 мянган төгрөгийн авлага, 1,312,122.4 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ. Өр төлбөрийн 58.02 хувь буюу 761,346.5 мянган төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл, НДШ-ийн зардал, үлдсэн хувьд хоол хүнс, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал эзэлж байна. Төрийн өмчийн 31 мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					2024 жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайлан системээр хүлээн авч БЕГ-ын төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хуулийн хугацаанд хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчдын хоорондын тооцооны зөрүүг арилган мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланд тайлагнан засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мэргэжлийн боловсролын дэмжих сангийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 195,737,496.7 мянган төгрөгийн санхүүжилтийг Сангийн яамнаас авч 183,843,623.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр МБСБ-дыг санхүүжүүлж 11,893,873.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлсэн нийт дүнгийн 97.78 хувь буюу 11,630,194.3 мянган төгрөг МБСБ-ын суралцагсадад олгох тэтгэлэг эзэлж байна. 2024 онд төрийн болон төрийн бус МБСБ-ын 14,282 суралцагчдад 43,406,400.0 мянган	
--	--	--	--	--	---	--

					төгрөгийн тэтгэлгийг олгсон байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг байгууллага бүрээр Засгийн газрын удирдлагын системтэй тулган, эдийн засгийн ангилал, хөтөлбөр зориулалтаар нь шалган баталгаажуулж нэгтгэсэн санхүүгийн тайланг холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлээ. Байгууллагын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, касс, харилцахын үлдэгдлийн баталгааг байгууллага бүрээр цаасаар хүлээн авч архивын нэгж бүрдүүлэн ажиллаж байна. Хавсралт: 3 файл		
4	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулах	Тэтгэлэгт хамрагдсан хүүхдийн тоо, Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын 14260 төгсөгчдөд нэг удаагийн тэтгэлэг олгосон.	Суралцагчид тэтгэлэг олгогдсон байна.	Өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад олгох тэтгэлгийн ажлыг 2025 оны 01-р сарын 14-ны өдрийн 1/248 дугаар албан бичгээр бүх байгууллагад чиглэл хүргүүлэн ЗГ-ын 421-р тогтоолын дагуу	1-р сар, 2-р сар, 3-р сар, 6-р сар, 7-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					суралцагчдын ирц, НДШ-ийн лавлагаа, нас, дансны дугаар, регистрийн дугаарыг тулган ирүүлэх маягтыг хүргүүлсэн. БЕГ-ын даргын 2025 оны 2-р сарын 14-ны өдрийн А/45 дугаар тушаалаар 3021 төгсөгчдөд 14,907,800.0 мянган төгрөг, 2025 оны 2-р сарын 19-ны өдрийн А/47 дугаар тушаалаар 3092 төгсөгчдөд 15,069,800.0 мянган төгрөг, 2025 оны 4-р сарын 3-ны өдрийн А/85 дугаар тушаалаар 446 төгсөгчдөд 1,373,600.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгох тушаал боловсруулж хэрэгжилтийн ханган ажилласан. 2025 оны өвлийн төгсөлтийн статистик тоогоор 45 сургуулийн 6915 суралцагчид төгсөж шаардлага хангасан 6559 суралцагчдад 31,351,200.0 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйлгээг нэг бүрчлэн төрийн сангийн программаар гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна. ЗГ-ын 421-р тогтоолын дагуу өвлийн төгсөлтөөр 6915 суралцагчдын шаардлага хангасан		
--	--	--	--	--	---	--	--

					эсэхийг нэг бүрчлэн тулган баталгаажуулж суралцагчдын ирцийг TVETS.edu.mn системтэй тулган статистикаас ирүүлсэн мэдээллийн дагуу мөн НДШ-ын лавлагаа, нас, анх удаа авч байгаа эсэх гэх мэт шаардлага хангасан суралцагчдын дансны мэдээлэл, регистрийн дугаараар тулгалт хийсэн. Хавсралт: 4 файл		
5	Төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын Улсын төсвөөс олгох санхүүжилтийг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, хяналт тавих ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах	Байгууллагын тоо, санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Төрийн бус өмчийн 31 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт олгосон	Төрийн бус өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад улсын төсвөөс олгож буй санхүүжилтийг гүйцэтгэл, үр дүнгээр олгосон байна.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 466 дугаар тогтоолын дагуу төрийн бус өмчийн 31 сургуульд олгох 2025 оны хувьсах зардалд 15,431,374.8 мянган төгрөгийн төлөвлөгөө батлагдсан. 2025 оны эхний 5 сарын байдлаар 6,014,137.7 мянган төгрөгийн төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 6,014,136.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Дараа сарын 5-ны дотор төрийн бус 30 мэргэжлийн болон техникийн боловсролын сургуулийн суралцагчдын ирцийн мэдээг курсээр, ангиар,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					мэргэжлийн индексээр хүлээн авч 3Г-ын 466 дугаар тогтоолын дагуу тооцоолол хийн санхүүжилтийг гүйцэтгэл, үр дүнгээр олгож төрийн сангийн удирдлагын нэгдсэн системээр гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна. Төрийн бус өмчийн МБТБСБ-ын хувьсах зардал олгох тухай эхний 4 сарын тушаалыг боловсруулан хэрэгжүүлж ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын 2025 оны 1,2,3-р сарын төрийн бус 374 цэцэрлэгийн санхүүжилтийг төсвийн мэргэжилтнээс хүлээн авч нийт 21,051,412.8 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн. Хавсралт: 4 файл		
1.3. НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ БИЕЛҮҮЛЭХ							
6	Үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааг төлөвлөх, мэргэжлийн боловсролын салбарын санхүү төсвийн мэргэжилтэн, нягтлан бодогчдыг манлайлах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэргэжил	Санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, зөвлөгөө, дэмжлэг хувь	Санхүү төсвийн мэргэжилтэн албан хаагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна	Санхүү төсвийн мэргэжилтэн албан хаагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна	Мэргэжлийн боловсролын сургалтын төрийн өмчийн 31 байгууллагын нягтлан бодогч нарт 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шинэ системээр хүлээн авахтай холбоотой сургалтыг цахимаар зохион байгуулж танилцуулсан. Шинэ системийн онцлог болон тайлан хоорондын уялдаа, хэрхэн шивж	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	арга зүйн удирдлагаар хангах				илгээх талаарх мэдээллийг цаг тухай бүрт нягтлан бодогч нарт мэдээлж ажилласан. Сангийн яамын Э-тайлан системээр тайлан хоорондын уялдаа, бариа, кодны зөрүүний талаарх мэдээллийг цаг тухай бүрт хүргэн, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Орон нутгийн Дархан, Сэлэнгэ, Увс, Завхан, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Булган, Баянхонгор, Баян-Өлгий, Төв аймгуудын гүйцэтгэл мэдээ хариуцсан мэргэжилтэнүүдэд сарын мэдээ, нэгтгэл мөн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хоорондын тооцоо, устгалын мэдээллийг хэрхэн хийх талаарх мэдээллийг цаг тухай бүрт нь хүргэн ажиллалаа. Эдгээр 11 аймгуудын төсвийн байгууллагуудын 2024 оны эхний, эцсийн дансны үлдэгдэл, санхүүжилтийг эхуулга, этайлан, эдийн засгийн ангилал, хөтөлбөр бүрээр хэрхэн тулгах талаарх мэдээллийг тухай бүр нь өгч ажиллаж дүнг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн		
--	---------------------------------	--	--	--	--	--	--

					байна. Шилэн дансны тухай хуулийн дагуу мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2025 оны 1-5 сарын мэдээ, мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүрээр оруулж, мэдээ, мэдээллийг бүртгэн олон нийтэд ил тод, нээлттэй түгээж байна. 2025 оны 04-р сарын 2-нд Ховд, Дундговь аймгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нарт санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, аудитын зөрчлийн талаарх мэдээллийг өгсөн. Хавсралт: 3 файл		
7	Мэргэжлийн боловсролын салбарын төсвийн тооцоо, судалгаанд шаардагдах гүйцэтгэл, үр дүнгийн мэдээллийг чанартай, заасан хугацаанд нь гаргаж өгөх	Санхүү, төсвийн хэвийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, хувь	Гүйцэтгэл, тайлан, мэдээний чанар, үр дүн	Чанартай мэдээллээр хангасан байна	МБТБСургалтыг дэмжих сангийн 2024 оны үйл ажиллагааны тайланг ЗГ-ын 194-р тогтоолын дагуу мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөлд 2025 оны 1-р сард тайлагнасан. Тус хуралд 2024 оны дэмжих сангийн төсвийн гүйцэтгэл, 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд хийгдэх ажлууд, цаашид хэрхэн ажиллах талаарх мэдээллийг БЕГ-ын дарга мэдээлэл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хүргэсэн. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэл, олгосон санхүүжилт, гүйцэтгэлийг Сангийн яамнаас ирүүлсэн судалгааны маягтын дагуу ЕБС-685, СӨБ-1004, НТБ-29, МБСБ-31 байгууллагын мэдээллийг тулган зөрүүтэй байгууллагуудын тайланг дахин нягтлан шалгаж зөрүүг арилгасан. Мөн 2024 оны жилийн эцсийн төсөвт байгууллагын төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийн судалгааг хөтөлбөр, зориулалтаар гарган 1003 цэцэрлэгийн дансанд 150,745,996.2 мянган төгрөг, 686 ерөнхий боловсролын сургуулийн дансанд 227,769,061.1 мянган төгрөг, 31 МБСБ-ын дансанд 8,174,513.7 мянган төгрөг, 29 НТБ-ын дансанд 3,685,611.9 мянган төгрөгийн үлдэгдлийн судалгааг гарган холбогдох мэргэжилтнүүдэд өгсөн байна.		
--	--	--	--	--	--	--	--

					Хавсралт: 3 файл		
3.1. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ							
8	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Ажлын чиг үүрэгт хамаарах чиглэлээр удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, мэдээ, судалгааг хугацаанд нь гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан	Хугацаанд нь тайлагнасан байна.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01-р сард боловсруулсан. 2025 оны гүйцэтгэлийн тайланг төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд нийцүүлэн ажилласан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд тухай бүрт хүргүүлэн ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
9	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Албан ажлын гүйцэтгэлийн явцад цуглуулсан холбогдох тайлан, мэдээ, мэдээлэл болох баримт бичгийг ААХХ-ийн зааврын дагуу үдэж хавтаслан архивын нэгж	2024 оны албан ажлын гүйцэтгэлийн явцад цуглуулсан холбогдох тайлан, мэдээ, мэдээлэл баримт бичгийг хугацаанд нь ААХХ-ийн зааврын дагуу нэгж бүрдүүлэн архивд хүлээлгэн	Албан ажлын ажлын гүйцэтгэлийн явцад цуглуулсан холбогдох тайлан, мэдээ, мэдээлэл, баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандарт, тухайн жилд хөтлөгдөх албан хэргийн нэр, тэдгээрийн хадгалах хугацааг тодорхойлж	1-р сар, 3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	100%

	болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх		бүрдүүлэн архивд хүлээлгэн өгсөн	өгч, ХАСХОМ мэдүүлсэн байна	гаргасан жагсаалтад заасны дагуу байгууллагын архивын нэгж болгон хуульд заасан хугацаанд хүлээлгэн өгөх бэлтгэлийг хангасан. Нийт архивын 15 баримтыг цэгцлэн архивын нэгж болгосон. АТГ-ын ХАСХОМ-д урьдчилсан мэдүүлэг бөглөн илгээсэн байна.		
--	--	--	----------------------------------	-----------------------------	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Монголын Мэргэшсэн Нягтлан бодогчийн институтын тасралтгүй боловсролын сургалтад хамрагдах	Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн байна.	Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн байна.	Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн байна.	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын тасралтгүй сургалтын хуваарийн дагуу багц сургалтанд цахимаар хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлж байна.	6-р сар, 10-р сар	100%
2	Монгол бичгийн	Мэдлэг,	Мэдлэг,	Мэдлэг,	Монгол бичгийн цахим хичээл,	3-р сар, 6-	100%

	мэдлэг дээшүүлэх	боловсрол дээшилсэн байна.	боловсрол дээшилсэн байна.	боловсрол дээшилсэн байна.	ТВ сувгийн хичээлд хамрагдан мэдлэгээ дээшлүүлж байна. Уран бичлэгийн цуврал видео хичээлийг судлан анхан шатны хичээлүүд болох үсэг бүрийг салган бичсэн 21 видео хичээл үзсэн.	р сар, 9-р сар, 12-р сар	
--	------------------	----------------------------------	----------------------------------	----------------------------------	--	--------------------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжлийн боловсролын салбарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлагнал хариуцсан мэргэжилтэн, Дашмятав Долгормаа
/...../ Огноо: